



**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар лиг” Сагсан бөмбөгийн шигшээ тэмцээнийг зохион байгуулах шаардагдах заал талбай түрээслэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Улаанбаатар лиг” Сагсан бөмбөгийн шигшээ тэмцээнийг 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах заалны түрээсийн зардал 2.000.000 /хоёр сая/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, спортын арга хэмжээ, байр түрээсийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД